



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 23 өдөр

Дугаар А/321

Чингис хот

Зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Засгийн газрын 2020 оны 62, 64, 102 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 25, 07 дугаар сарын 09-ний өдрийн 26 дугаар хурлын шийдвэрүүд, аймгийн Онцгой комиссын №27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн хуулийн этгээдээс зохион байгуулах олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахгүй байх, РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарны үйл ажиллагааг явуулахгүй байхыг сумдын Засаг дарга, Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/-т үүрэг болгосугай.

2. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд коронавируст ковид цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн хяналтын үйл ажиллагааг буулгаж, ажлын тусгай горимоор ажиллаж байгаа байгууллагуудыг энгийн горимд шилжүүлсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Онцгой байдлын газрын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА